

# **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ**

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь геодези, зураг зүйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж**

2.1.Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын хилийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Барилгын тухай хууль, Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Хот байгуулалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“байнгын ажиллагаатай суурин станц” гэж навигацын хиймэл дагуулын дохио хүлээн авах, хадгалах, боловсруулах, өөрийн солбицол, өндрийг тухайн агшин бүрт тодорхойлох, мэдээллээ хэрэглэгчдэд түгээх байнгын тасралтгүй үйл ажиллагаатай иж бүрэн цахим төхөөрөмж бүхий байгууламжийг;

3.1.2.“байр зүйн зураг” гэж газрын гадарга, түүний дээрх болон доорх объектыг тусгагт оруулан, тодорхой масштабээр жижигрүүлэн буулгаж, таних тэмдгээр дүрсэлж, үзүүлэлт, шинж чанарыг нь илэрхийлсэн газрын зургийг;

3.1.3.“байрлалын сүлжээ” гэж хэвтээ солбицлыг нь тэгшитгэн бодож тодорхойлсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлогийг;

3.1.4.“бие даасан солбицлын тогтолцоо” гэж орон зайн цэгүүд ба тэдгээрийн солбицлын тоон утгыг орон нутаг дахь геодезийн сүлжээний эхлэлийн цэгээс харьцуулан тогтоосон дүрмийг;

3.1.5."газар зүйн нэр" гэж газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор оноосон нэрийг;

3.1.6."газрын зураг" гэж дэлхийн гадаргуу, огторгуй ертөнцийн бусад бодит биет буюу тэдгээрийн хэсгийг хавтгайд тодорхой масштаб, тусгаг, таних тэмдэг ашиглан жижигрүүлэн буулгаж дүрсэлснийг;

3.1.7."газрын зургийн нэг маягийн суурь" гэж жижиг масштабын газрын зураг зохиоход ашиглах нийтлэг өгөгдөл агуулсан зургийг;

3.1.8."геодези" гэж дэлхий, гараг эрхсийн хэлбэр, хэмжээ тэдгээрийн туйлын, царцдасын, гадаргын шилжих хөдөлгөөн, таталцлын орныг тодорхойлох зорилгоор цэгийн байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг цаг хугацаатай уялдуулан хэмжиж, математик боловсруулалт хийх цогцолбор үйл ажиллагааг;

3.1.9."геодезийн байнгын цэг, тэмдэгт" гэж геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох байрлал, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газрын гадарга, хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн төв цэг болон түүн дээрх байгууламжийг;

3.1.10."геодези, зураг зүйн ажлын захиалагч" гэж геодези, зураг зүйн ажил гүйцэтгүүлэх сонирхол бүхий иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;

3.1.11."геодезийн сүлжээ" гэж орон зайн гурав ба түүнээс дээш хэмжээст утгыг тэгшитгэн бодож тодорхойлсон геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тогтолцоог ойлгох ба байрлалын, өндрийн, гравиметрийн гэж ангилагдана;

3.1.12."геодезийн хэмжилтийн багаж хэрэгсэл" гэж өнцөг, өндөр, зай, хүндийн хүчний хурдатгал болон цэгийн байрлалыг орон зайн гурав болон түүнээс дээш хэмжээсээр тодорхойлох багажийг;

3.1.13."гравиметрийн сүлжээ" гэж гравиметрийн хэмжилтээр хүндийн хүчний хурдатгалын утгыг нь тэгшитгэн бодож тодорхойлсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлогийг;

3.1.14."гүйцэтгэлийн зураг" гэж шинээр болон өөрчлөн барьж байгуулсан объект, зам, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн бодит байршлыг газрын гадаргын өөрчлөлттэй нь харуулсан байр зүйн болон дэвсгэр зургийг;

3.1.15."дэвсгэр зураг" гэж газрын гадарга, барилга болон инженерийн байгууламжийн бодит байршлыг тусгагт оруулаагүй, газрын гадаргын махиаг тооцолгүй батлагдсан түвшинд хэмжиж, дүрсэлснийг;

3.1.16."Жижүүрлэлтийн зураг" гэж газрын зургийн агуулгын өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, тэмдэглэсэн зургийг;

3.1.17."зураг зүй" гэж газрын гадаргын дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцан хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм,

эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг зохиож хэвлэх үйл ажиллагааг;

3.1.18."зурагжуулах" гэж төрөл бүрийн масштабтай газрын зургаар нутаг дэвсгэрийг хангах үйл ажиллагааг;

3.1.19."инженерийн барилга байгууламж" гэж Барилгын тухай хуулийн 4.1.1, 4.1.33, 4.1.35-ыг хамтад нь ойлгоно;

3.1.20."кадастрын зураг" гэж геодезийн хэмжилтээр газрын болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн, газрын кадастрын судалгааны үйл ажиллагаанд шаардагдах байршил, хил зааг, талбайн хэмжээг тодорхойлсон газрын зургийг;

3.1.21."магадлал хийх" гэж геодези, зураг зүйн ажлын үр дүн нь геодези, зураг зүйн норм, нормативийн баримт бичгийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргах хараат бус мэргэжлийн үйл ажиллагааг;

3.1.22."масштаб" гэж газрын зурагт дүрсэлсэн хэрчмийн уртыг газар дээрх бодит урттай нь харьцуулсан харьцааг;

3.1.29."ортофото зураг" гэж агаар, сансрын гэрэл зургийн газрын гадаргуу болон камерын линзийн геометрийн гажилтыг тэгш өнцгийн тусгалаар засаж үүсгэсэн ижил масштабтай гэрэл зургийн дүрсийг;

3.1.23."өндөржилтийн зураг" гэж хот байгуулалт, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний өндрийн төлөвлөлтийн зургийг;

3.1.24."өндрийн сүлжээ" гэж өндрийг нь тэгшитгэн бодож тодорхойлсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлогийг;

3.1.25."солбицлын тогтолцоо" гэж орон зайн цэгүүд ба тэдгээрийн солбицлын тоон утгыг геодезийн сүлжээний эхлэлийн цэгээс харьцуулан тогтоосон дүрмийг;

3.1.26."сэдэвчилсэн газрын зураг, атлас" гэж газрын зургийн нэг маягийн суурь ашиглан зохиосон тухайлсан агуулга, зориулалт бүхий газрын зураг, атласыг;

3.1.27."тэг тэнхлэг" гэж инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн үндсэн хэмжээ, түвшинг улсын геодезийн сүлжээнд холбосон газар дээрх тэмдэглэгээг;

3.1.28."Үндэсний референц эллипсоид" гэж Монгол улсын нутаг дэвсгэрийн бодит гадаргууг бүхэлд нь эсвэл түүний тодорхой хэсэгт хамгийн их нийцтэй байхаар тодорхойлсон эсвэл сонгосон эллипсоидыг;

3.1.29."фотограмметр" гэж газрын гадаргуу, төрөл бүрийн объект биетүүдийн орон зайн байрлал хэмжээ хэлбэр дүрсийг тэдгээрийн гэрэл зургаар нь тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.30."хаягийн зураг" гэж засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бүрээр газар нутаг, гудамж зам талбай, үйлдвэр, аж ахуйн нэгж, хотхон,

төлөвлөлтгүй суурьшсан хэсэг зэрэгт харьяалагдах үл хөдлөх эд хөрөнгийн нэр дугаар байршлыг дүрсэлсэн сэдэвчилсэн газрын зургийг;

#### **4 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн салбарт баримтлах зарчим**

4.1.Геодези, зураг зүйн салбарт дараахь зарчмыг баримтална:

4.1.1.Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь геодезийн хэмжилт, газрын зургаар баталгаажна.

4.1.2.геодези, зураг зүйн үйл ажиллагааны зохицуулалт, бүртгэл, зөвшөөрлийг олон нийтэд ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулах;

4.1.3.геодези, зураг зүйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах;

4.1.4.геодези, зураг зүйн үйл ажиллагааг солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд гүйцэтгэх;

4.1.5.хэмжлийн нэгдмэл байдлыг хангах.

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

#### **ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

#### **5 дугаар зүйл.Геодези, зураг зүйн үйл ажиллагаа**

5.1.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна:

5.1.1.үндэсний референц эллипсоид, солбицол, өндрийн тогтолцоо, геоидын өндрийн загвар, тусгагийг тодорхойлох, нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, солбицлын тогтолцоо хооронд хөрвүүлэх, солбицол, өндрийн утгын цаг хугацааны өөрчлөлтийг тогтоох, Дэлхийн хэлбэр хэмжээ, түүний хүндийн хүчний таталцлын талбарыг тодорхойлох;

5.1.2.газрын гадаргуугийн цэг, орон зайн биетийн солбицол, өндрийг тодорхойлох, тэдгээрийн орон зайн харилцан байршлыг нь тогтоох зорилгоор геодезийн хэмжилт, боловсруулалт хийх;

5.1.3.улсын геодезийн байрлалын, өндрийн ба гравиметрийн сүлжээ байгуулах, цэг, тэмдэгтийн нягтрал, сүлжээний нарийвчлалыг сайжруулах;

5.1.4.геодезийн байнгын цэг, тэмдэгтийг барьж байгуулах, сэргээх, тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах;

5.1.5.Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг зурагжуулах, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн газрын зураг зохиох, шинэчлэх;

5.1.6.зайнаас тандан судлах, агаар, сансрын зураглал, фотограмметрийн боловсруулалт хийх;

5.1.7.улсын хилийн тэмдэгтийн байршлыг геодезийн аргаар тодорхойлох, хилийн шугамын дагуу газрын зураг үйлдэх;

5.1.8.засаг захиргааны нэгж, тусгай хэрэгцээний газрын хил заагийн эргэлтийн цэгийн солбицлыг тодорхойлох;

5.1.9.геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг байгуулах, баяжуулах, хөтлөх;

5.1.10.үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг суурь өгөгдөл, мэдээллээр хангах;

5.1.11.газрын зураг, атлас зохиох, хэвлэх;

5.1.12.газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, нэрийн зураг үйлдэх, хувийн хэрэг хөтлөх, мэдээллийн сан байгуулах;

5.1.13.газар зүйн нэрийг зөв бичих, хөрвүүлэх, газрын зурагт тусгах, тайлбар толь бичиг, жагсаалт, лавлах боловсруулж хэвлэх, лавлагаа гаргах;

5.1.14.газар, хот байгуулалт, үл хөдлөх хөрөнгө, соёлын өв, инженерийн барилга байгууламж, геологи, уул уурхай, хөдөө аж ахуй, байгаль орчин, түүх, археологи, палеонтологийн кадастрын зураглал үйлдэх;

5.1.15.газар зохион байгуулалтын болон хот, тосгон, бусад суурины хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийн төлөвлөлт, барьж байгуулах, ашиглалтын үеийн геодезийн хэмжилт хийх, газрын зураг үйлдэх, шинэчлэх, орон зайн мэдээллийн сан үүсгэх;

5.1.16.геологи, уул уурхай, ашигт малтмал, геофизикийн хайгуулын геодезийн хэмжилт хийх, газрын зураг үйлдэх, шинэчлэх, мэдээллийн сан үүсгэх;

5.1.17.хот байгуулалтын геодезийн торон сүлжээ байгуулах, өндөржилт төлөвлөлтийн зураг төсөл зохиох;

5.1.18.геодези, зураг зүйн салбарт шинжлэх ухааны туршилт, судалгаа явуулах, програм хангамж, багаж тоног төхөөрөмж зохион бүтээх, үйлдвэрлэл, үйлчилгээнд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх;

5.1.19.улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, гамшигаас урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үед геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх;

5.1.20.өндөр уулсын ноёлох оргилын солбицол, өндрийг тодотгон тогтоох, экологийн тогтолцооны газрын зураг зохиох, шинэчлэх;

5.1.21.усны хайгуул судалгааны ажлын геодезийн хэмжилт зураглал үйлдэх, нуур, гол, усан сан тэдгээрийн ёроолын зураглал, усан замын газрын зураг зохиох;

5.1.22.хаягийн зураг зохиох, хаягийн жагсаалт үйлдэх, хаягийн тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах;

5.1.23.бүх төрлийн газрын зурагт жижүүрлэлт хөтлөх;

5.1.24.далан, гүүрийн мониторинг, барилга, байгууламжийн суулт, хазайлтыг тодорхойлох;

5.1.25.геодезийн хэмжлийн багаж шалгах, засварлах, тохируулга хийх, баталгаажуулах;

5.1.26.инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн тэг тэнхлэг байгуулах;

5.1.27.соёлын өвийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, уламжлуулах, өвлүүлэх, сурталчлах чиглэлээр геодезийн хэмжилт, зураглалын ажил хийх;

5.1.28.уул уурхай, газрын гүний геодезийн хэмжилт, зураглалын ажил хийх.

## **6 дугаар зүйл.Монгол Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажил**

6.1.Батлан хамгаалах, улсын хилийг тодотгох болон эдийн засгийн тусгай бүс нутагт гүйцэтгэж буй геодези, зураг зүйн ажлыг хамааруулна.

6.2.Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэж буй геодези, зураг зүйн ажлыг батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ.

6.3.Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэж буй геодези, зураг зүйн ажлыг зохион байгуулахад шаардлагатай батлан хамгаалахын болон геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хоорондын харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

## **7 дугаар зүйл.Солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо**

7.1.Геодези, зураг зүйн ажлыг олон улсын, улсын, бие даасан солбицлын тогтолцоо, улсын өндрийн тогтолцоо, улсын гравиметрийн тогтолцоонд гүйцэтгэнэ.

7.2.Улсын солбицлын, өндрийн, гравиметрийн тогтолцоог Засгийн газар батална.

7.3.Солбицлын бие даасан тогтолцоог хот байгуулалт, уул уурхай, инженерийн барилга байгууламжийн геодези, зураг зүйн ажил гүйцэтгэхэд ашиглаж болох ба улсын солбицлын тогтолцоонд холбох хөрвүүлэлтийн утгыг тогтооно.

## **8 дугаар зүйл.Геодезийн сүлжээ**

8.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн хэлбэр хэмжээ, түүний хэвтээ болон босоо шилжилт хөдөлгөөнийг шинжлэн судлахад байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээг байгуулна.

8.2.Улсын геодезийн сүлжээг улсын геодезийн солбицлын тогтолцоонд, геодезийн сүлжээний эхлэл цэгт тулгуурлан байгуулна.

8.3.Улсын геодезийн сүлжээний бүрэлдэхүүнд байнгын ажиллагаатай суурин станц багтана.

8.4.Улсын геодезийн байрлалын сүлжээг 6-8 жил тутамд, өндрийн болон гравиметрийн сүлжээг 15 жил тутамд, хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдолд тухай бүр давтан хэмжиж шинэчлэнэ.

8.5.Улсын геодезийн сүлжээний бүтэц болон түүнийг байгуулах, геодезийн байнгын цэг тэмдэгтэд тавих шаардлагыг геодези, зураг зүйн дүрмээр тогтооно.

## **9 дүгээр зүйл.Геодезийн байнгын цэг, тэмдэгт**

9.1.Төрийн болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөрийн хүрээнд байгуулсан геодезийн сүлжээний байнгын цэг, тэмдэгт нь төрийн өмч байна.

9.2.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, ашиглахад холбогдох стандарт, дүрмийг баримтална.

9.3.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хамгаалалтын бүс нь төв суурин газарт цэгийн төвөөс эргэн тойронд 1.5 метр, хөдөө орон нутагт 3 метр газрыг хамарна.

9.4.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тухай өгөгдөл, мэдээллийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан ёсны цахим мэдээллийн санд байршуулна.

9.5.Монгол Улсын нутаг дэвсгэрт Улсын геодезийн сүлжээ, байнгын цэг, тэмдэгтийг байгуулах, шигүүрүүлэх ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

9.6.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн техникийн үзүүлэлтэд хяналт үнэлгээ, мониторинг хийх ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

9.7.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн техникийн үзүүлэлтэд хяналт үнэлгээ, мониторинг хийх дүрэм, журам болон тэдгээрийн талаарх өгөгдөл, мэдээллийн бүрдлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.8.Улсын геодезийн сүлжээний байнгын ажиллагаатай суурин станцын антенаас эргэн тойронд 100 метр газрыг улсын тусгай хэрэгцээнд авна.

9.9.Хамгаалалтын бүс болон тусгай хэрэгцээнд авсан газарт геодезийн байнгын цэг тэмдэгт болон гадна тэмдэгтийг эвдэлж гэмтээх, цэгийн төвийн хөдөлгөөнгүй байдал ба хэмжилт хийх, түүнд чөлөөтэй хүрч очих нөхцлийг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

9.10.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга, Хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна. Уг цэгийг нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлага гарвал түүнийг сэргээн босгох зардлыг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

9.11.Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газар, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь түүнийг хамгаалах, геодезийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

9.12.Нутаг дэвсгэртээ байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

9.13.Хилийн зурваст байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хил хамгаалах байгууллага, тухайн цэг байрлаж байгаа нутаг дэвсгэр дэх хилийн анги хяналт тавина.

9.14.Тусгай хэрэгцээний газарт байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хариуцсан захирагч хяналт тавина.

9.15.Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулсан тохиолдолд Засаг дарга, хил хамгаалах ерөнхий газар нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.

## **10 дугаар зүйл.Газрын зургийн төрөл, ангилал, агуулга, нарийвчлал, хэрэглээ**

10.1.Газрын зургийг агуулга, хэрэглээнээс хамааруулан дараах төрөлд хуваана:

10.1.1.байр зүйн зураг;

10.1.2.дэвсгэр зураг;

10.1.3.хаягийн зураг;

10.1.4.гүйцэтгэлийн зураг;

10.1.5.кадастрын зураг;

10.1.6.өндөржилт төлөвлөлтийн зураг;

10.1.7.газар зүйн нэрийн зураг;

10.1.8.ортофото зураг;

10.1.9.сэдэвчилсэн газрын зураг, атлас

10.1.10.жижүүрлэлтийн зураг

10.1.11.бусад.

10.2.Газрын зургийг масштабээр нь том, дунд, жижиг гэж ангилна.

10.2.1.том масштабын газрын зурагт 1:100, 1:200, 1:500, 1:1000, 1:2000, 1:5000,

10.2.2.дунд масштабын газрын зурагт 1:10 000, 1:25 000, 1:50 000, 1:100 000, 1:200 000,



10.2.3. жижиг масштабын газрын зурагт 1:500000 ба түүнээс жижиг масштаб хамаарна.

10.3. Улсын хэмжээний байгаль, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг дүрсэлсэн сэдэвчилсэн газрын зураг, атласт жижиг масштабын, бүс нутгийн болон аймгийн хөгжлийн төлөвлөлтөд дунд масштабын, хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлтөд том масштабын байр зүйн, хэсэгчилсэн төлөвлөлтөд том масштабтай дэвсгэр зургийг ашиглана.

10.4. Газрын зургийн нарийвчлал ба агуулга нь нийт улс орны хэмжээний болон батлан хамгаалах, бусад тусгай зорилтын нөхцөл шаардлагыг хангасан байна.

10.5. Байр зүйн болон дэвсгэр зураг нь орон зайн биетийн хавтгайн болон өндрийн байрлалыг нь тодорхойлох боломжтой, улс, засаг захиргааны нэгжийн хил, хот суурин, хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, гүүр, усан сан, суваг, хөшөө, түүх соёлын дурсгалт газар, газар зүйн нэр, ойн сан, эргийн шугам \усан сангийн хил\, газрын гадаргуу, ус зүй, газрын бүрхэвч, барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ бусад мэдээллийг агуулсан байна.

10.6. Нийтийн хэрэгцээний бүх масштабын газрын зургийг зохиох, шинэчлэх, хэрэглээнд гаргах асуудлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн зохион байгуулна.

10.7. Газрын зургийг геодези, зураг зүйн нэгдсэн санд хадгалагдаж буй орон зайн өгөгдөл, мэдээллийг ашиглан зохионо.

10.8. Байр зүйн болон дэвсгэр зургийг зориулалтаар нь тусгай зориулалтын болон нийтийн зориулалтын гэж ангилна.

10.8.1. Тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зураг нь төрийн болон албаны нууцад хамаарсан мэдээллийг агуулсан, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад зориулсан байна.

10.8.2. Нийтийн зориулалтын байр зүйн болон дэвсгэр зураг нь энэ хуулийн 10.8.1-д заасан мэдээллийг агуулаагүй байна.

10.9. Тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зурагт дүрслэгдэх нууц элементийн жагсаалтыг Засгийн газар батална.

10.10. Нийтийн зориулалтын байр зүйн зургийн агуулга, тавигдах шаардлагыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

10.11. Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан дунд масштабын байр зүйн зургийг 10 жил тутамд улсын төсвийн хөрөнгөөр, хот суурин газрын байр зүйн болон дэвсгэр зургийг нийслэлд 2 жил тутамд, бусад суурин газарт 3 жил тутамд орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэчилнэ.

10.12. Жижиг масштабын газрын зургийн жижүүрлэлтийг өөрчлөлт гарсан тухай бүрт хөтөлнө.

10.13.Дэвсгэр зургийг газрын гадаргуугийн махиаг үл тооцсон, газар нутгийн хязгаарлагдмал талбайд том масштабаар үйлдэнэ.

10.14.Сэдэвчилсэн газрын зургийг үндсэн агуулга, дүрсэлж буй сэдвээр зохионо.

10.15.Нийтийн хэрэгцээний болон сургалтад зориулсан сэдэвчилсэн газрын зураг, атласыг зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж зохионо.

10.16.Сэдэвчилсэн газрын зураг, атласд тавигдах шаардлагыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

10.17.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийтийн хэрэгцээний газрын зураг, мэдээллээр хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.

10.18.Тусгай зориулалтын байр зүйн зураг зохиох, шинэчлэх, тэдгээрийг тоон хэлбэрт шилжүүлэх, хэвлэх, ашиглах асуудлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох бусад төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

## **11 дүгээр зүйл.Газар зүйн нэр**

11.1.Газар зүйн нэрэнд дараахь объектын нэр хамаарна:

11.1.1.эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр тал, говь, цөл, гол, мөрөн, нуур, тойром, байгалийн үзэсгэлэнт газар, зэрэг физик газар зүйн объект;

11.1.2.улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж;

11.1.3.хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, гүүр, усан сан, суваг, хөшөө, түүх соёлын дурсгалт газар.

11.2.Газар зүйн нэрийг тодотгох, шинээр нэрлэхэд лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд аливаа эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүх, угсаатан зүй, монгол хэлний эрдэмтэн судлаачдын саналыг үндэслэнэ.

11.3.Иргэн, хуулийн этгээдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээллээр хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, хэвшүүлэх асуудлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран зохион байгуулна.

11.4.Газар зүйн нэрийг шинээр нэрлэхэд дараахь зарчим баримтална:

11.4.1.тухайн объектыг нээх, судлах, барьж байгуулахад оролцсон буюу эзэмшиж байгаа, эсвэл төр нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх зорилгоор хүний нэрээр нэрлэх;

11.4.2.газар зүйн хуучин нэрээр нь зүг чиг, өнгө, цаг хугацааны тодотголтой нэрлэх;

11.4.3.ойролцоо орших өөр төрлийн объектуудын нэртэй ижил нэртэй байж болох;

11.4.4.газар зүйн нэрийг газар орны онцлог, түүхэн үйл явдал, ард түмний ёс заншил, уламжлал зэргийг харгалзан нэрлэж, өөрчлөх тухай тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэнэ.

11.4.5.монгол хэлний бичлэг, хэллэгт тохиромжтой гурваас илүүгүй үгээс бүтсэн байх.

11.5.Газар зүйн нэрийг уугуул иргэд нь нэрлэж заншсан уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан тохиолдолд өөрчилж болно.

11.6.Монгол улсын Засгийн газрын дэргэд орон тооны бус газар зүйн нэрийн Үндэсний зөвлөл ажиллана.

11.7.Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

11.8.Газар зүйн нэрийг шинээр өгөх, өөрчлөх асуудлыг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн барьж шийдвэрлүүлнэ.

11.9.Газар зүйн нэрийг 10 жил тутамд тодотгон баталгаажуулна.

11.10.Газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, газар зүйн нэрийн зураг үйлдэх, мэдээллийн сан үүсгэх, жагсаалт хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, зөв бичих, газрын зурагт тусгах, хөрвүүлэх, лавлагаа гаргах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан норм, дүрэм, журмыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

11.11.Газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх асуудлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ.

## **12 дугаар зүйл. Геодези, зураг зүйн зөвлөх үйлчилгээ**

12.1. Геодези, зураг зүйн салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээг дараахь чиглэлээр үзүүлнэ:

12.1.1.геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл зохиох;

12.1.2.геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах;

12.1.3.геодези, зураг зүйн ажлын чанар, технологийн хяналт, зөвлөгөө, дүгнэлт гаргах;

12.1.4.техник, технологийн үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох;

12.1.5.багаж, тоног төхөөрөмжийн угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах;

12.1.6. төслийн удирдлага, зохион байгуулалт;

12.2.өндөр төвөгшилтэй, онцгой төвөгшилтэй барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн, инженерийн шугам сүлжээний угсралтын болон дараах үеийн үйл ажиллагаанд геодези, зураг зүйн зөвлөх үйлчилгээг заавал авна.

12.3.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

12.4.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгжид тавих шаардлага, бүртгэх журмыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **13 дугаар зүйл. Геодези, зураг зүйн салбарын даатгал**

13.1. геодези, зураг зүйн үйл ажиллагаанд оролцогч учирч болзошгүй эрсдлийг даатгуулж болно.

13.2. геодези, зураг зүйн ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгж ажлын хариуцлагын даатгалд даатгуулж болно.

13.3. геодези, зураг зүйн мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.

13.4. геодези, зураг зүйн ажлын гүйцэтгэгч ажилтнуудыг амь насны даатгалд хамруулна.

### **14 дугаар зүйл. Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг**

14.1. Геодези, зураг зүйн үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна:

14.1.1. Геодези, зураг зүйн дүрэм;

14.1.2. Геодези, зураг зүйн журам, заавар, аргачлал;

14.1.3. Стандарт.

14.2.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд энэ хуулийн 14.1-д заасан Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгийг заавал мөрдөнө.

14.3.Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгээр геодези, зураг зүйн үйл ажиллагааны нарийвчилсан нөхцөл, шаардлагыг тогтооно.

14.4. Энэ хуулийн 14.1-д заасан Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, хэвлэх, сурталчлах зэрэг үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон Геодези, зураг зүйн норм, нормативын сангаас санхүүжүүлнэ.

14.5. Геодези, зураг зүйн норм, нормативын сангийн журмыг Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

14.6. Геодези, зураг зүйн норм, нормативын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

14.6.1.Геодези, зураг зүйн ажлын төсөвт өртгөөс нэг хувиар авсан орлого;

14.6.2.норм, нормативын баримт бичгийн борлуулалтын орлого;

14.6.3.норм, нормативыг боловсронгуй болгох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын орлого;

14.6.4.бусад орлого.

14.7.Геодези, зураг зүйн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчлах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулна.

14.8.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дагаж мөрдөх стандартыг боловсруулах, батлах, ашиглах, тохирлын гэрчилгээ олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

14.9.Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгийг Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хэвлэхийг хориглоно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ.**

### **ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ**

#### **15 дугаар зүйл.Улсын их хурлын бүрэн эрх**

15.1.Улсын их хурал геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

15.1.2.улсын хилийн шугамын дагуух байр зүйн зураг, хилийн тэмдэгтийн солбицол, өндөр, хилийн цэсийг батлах;

15.1.3.газар зүйн нэрийг батлах;

15.1.4.1:25000-аас багагүй масштабтай газрын зурагт дүрсэлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зураг, солбицлын жагсаалтыг батлах;

#### **16 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

16.1.Засгийн газар геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо, тусгаг, солбицлын эрин, геодезийн эхлэл цэгийн өгөгдөхүүнийг батлах;

16.1.2.олон улсын баримт бичигт тусгах, газрын зурагт хэрэглэгдэх Монгол Улсын газар зүйн нэр, засаг захиргааны нэгжийн хил, түүний өөрчлөлтийн талаархи мэдээллийг холбогдох олон улсын байгууллагатай солилцох;

16.1.3.төрөөс геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг батлах;

16.1.4.геодези, зураг зүйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор геодези, зураг зүйн үйл ажиллагааны журам батлах;

16.1.5.газар зүйн нэрийн үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах;

16.1.6.Монгол улсын геодезийн сүлжээний цэг, тэмдэгтийн нягтралын хэмжээг тогтоох.

## **17 дугаар зүйл.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

17.1.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

17.1.2.геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;

17.1.3.Монгол Улсын геодезийн тулгуур сүлжээг нягтруулах, шинэчлэх, нутаг дэвсгэрийг зурагжуулах төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавих;

17.1.4.геодези, зураг зүйн үйл ажиллагаанд баримтлах журам, норматив баримт бичгийг батлах, мөрдүүлэх;

17.1.5.олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

17.1.6.Аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, цуцлах, тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг тодорхойлсон журмыг баталж, мөрдүүлэх;

17.1.7.Аж ахуйн нэгжид геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

17.1.8.Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ, үнийн индекс батлах;

17.1.9.Геодези, зураг зүйн салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох журам батлах;

17.1.10.Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник эдийн засгийн үндэслэл, техникийн төслийг батлах;

17.1.11.Геодези, зураг зүйн салбарын боловсон хүчний бодлогыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тодорхойлох;

17.1.12.Геодези, зураг зүйн ажилд магадлал хийх журмыг батлах;

## **18 дугаар зүйл. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

18.1.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;

18.1.2.энэ хуулийн 5.1.1-5.1.28-д заасан үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.3.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.4.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын даалгавар боловсруулж, батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

18.1.5.геодезийн хэмжилтийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээ байгуулах, өргөтгөх, хэвийн ажиллагааг хангах, ашиглуулах;

18.1.6.тусгай зориулалтын байр зүйн зургийн зохиолт, хэвлэлт, ашиглалт, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хянах, шалгах;

18.1.7. геодези, зураг зүйн ажилд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

18.1.8.геодезийн хэмжлийн багаж, хэрэгсэл шалгах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, багажны бүртгэлийн мэдээллийн сан хөтлөх;

18.1.9.геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ, үнийн индекс, норм, дүрэм, журам боловсруулах, батлуулах, мөрдүүлэх;

18.1.10.геодези, зураг зүйн заавар, аргачлал батлах, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэх;

18.1.11.газрын зургийн нэг маягийн суурь зохиох, шинэчлэх, батлах, хэрэглээнд хяналт тавих;

18.1.12.бүх төрлийн сэдэвчилсэн газрын зураг, атласын зохиолтын эхэд мэргэжлийн дүгнэлт өгөх;

18.1.13.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлыг улсын нэрийн өмнөөс шалгаж хүлээн авч геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд төвлөрүүлэх;

18.1.14.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах;

18.1.18.геодези, зураг зүйн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

18.1.16.Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх болон мэргэшлийн зэрэг олгох сургалт зохион байгуулах;

18.1.17.зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

18.1.18.салбарын норм, нормативын баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулах.

18.2.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй газрын зургийн зохиолт, хадгалалтыг хариуцах бөгөөд төрийн тусгай хамгаалалтад байна.

## **19 дүгээр зүйл.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

19.1.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага геодези, зураг зүйн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжийн биелэлтийг харьяалсан салбартаа зохион байгуулах;

19.1.2.салбарын хүрээнд дараа жил хийгдэх геодези, зураг зүйн ажлын саналыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж өгөх;

19.1.3.өөрийн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын даалгавар, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хүлээн авах ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах, геодези, зураг зүйн үйл ажиллагааны журмыг мөрдөх;

19.1.4.салбарын орон зайн мэдээллийн санг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээлэлтэй уялдуулах ажлыг зохион байгуулах;

19.1.5.газрын зурагт тусгуулах салбарын мэдээ, мэдээллээр хангах;

19.1.6.салбарын хэмжээнд гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын даалгавар, техникийн төслийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулах;

19.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын газрын зураг, атласын хэрэгцээ, шаардлага, агуулгыг Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.

19.3.Төрийн байгууллага геодезийн хэмжилтийн байнгын ажиллагаатай суурин станцыг байгуулж, ашиглах бол геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөж байршлыг тогтооно.

19.4.Батлан хамгаалахын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага цэргийн зориулалтаар хийж буй геодези, газрын зургийн ажилд хяналт тавина.

## **20 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг**



20.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга геодези, зураг зүйн талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1. геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

20.1.2. нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгагдах газар зүйн нэр, хил, шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объектын талаархи мэдээлэл, нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих, тайланг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлэх;

20.1.3. геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн харьяа нутаг дэвсгэрт нь хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавих;

20.1.4. нутаг дэвсгэртээ хамаарах батлагдсан газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, шинэ нэрийн талаар санал дэвшүүлэх;

20.1.5. нутаг дэвсгэртээ хамаарах газрын зургийг гүйцэтгэлийн зургаар шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

20.1.6. орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, газрын зургийн ажлын техникийн даалгавар, техникийн төслийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулах;

20.1.7. энэ хуулийн 10.11-д заасан үйл ажиллагаа, геодезийн байнгын цэг, тэмдэгтийг тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгуулах;

20.1.8. орон нутгийн төсвөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийлгэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ**

#### **21 дүгээр зүйл. Төрийн бус байгууллагын оролцоо**

21.1. Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авах, дүгнэлт гаргах, салбарын хуулийн этгээдийг бүртгэх, салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, геодези, зураг зүйн зөвлөх үйлчилгээ, геодези, зураг зүйн ажилд магадлал хийх, салбарын норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

21.2. энэ хуулийн 21.1 дэх хэсэгт заасан ажлыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

#### **22 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг**

22.1. Геодези, зураг зүйн ажил захиалагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.1.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.4.1-д заасны дагуу үйл ажиллагааныхаа талаар тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргаа, иргэдэд мэдээлэх;

22.1.2.улсын магадлалын дүгнэлтийг биелүүлэх;

22.1.3.энэ хуулийн 5.1-д заасан үйл ажиллагааны захиалагч нь Геодези, зураг зүйн үйл ажиллагааны журамд заасны дагуу өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ажлын үр дүнг геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлэх;

22.1.4.Энэ хуулийн 27.4-д заасан нэгдсэн санд байгаа мэдээллийг ашиглах;

22.1.5.Энэ хуулийн 27.7-д заасан мэдээллийг шаардан авах;

22.1.6.норм, нормативын баримт бичгийг баримтлан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах;

22.1.7.геодези, зураг зүйн ажилд магадлал хийлгэж, холбогдох зардлыг хариуцах;

22.1.8.геодези, зураг зүйн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцан зохицуулж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд хийх;

22.1.9.геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс үүсэх эрсдэл, хохирлыг хариуцах;

## **23 дугаар зүйл. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх, үүрэг**

23.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь дараах эрх, үүрэгтэй:

23.1.1. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх;

23.1.2.геодезийн хэмжлийн багажинд жил тутамд, эвдрэл гэмтэл гарсан нөхцөлд тухай бүрд баталгаажуулалт хийлгэх;

23.1.3.геодезийн хэмжилт, зураглалыг батлагдсан солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо, эрин, тусгагт хийх;

23.1.4.бие даасан солбицлын тогтолцоонд геодезийн хэмжилт, зураглалыг гүйцэтгэсэн бол улсын солбицлын тогтолцоонд холбох хөрвүүлэлтийн утгыг тогтоох;

23.1.5.геодези, зураг зүйн тухай хууль, Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг, Улсын их хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, норм, нормативын баримт бичгийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;

23.1.6.нийтийн хэрэгцээнд зориулсан төрөл бүрийн сэдэвчилсэн, лавлагааны, сургалтын газрын зураг, атлас зохиохдоо нэг маягийн суурь зураг ашигласан байх;

23.1.7.газрын зураг, атлас зохиох, хэвлэхдээ геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн дүгнэлт гаргуулсан байх;

23.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулсан бол уг цэгийн байрлаж байгаа сум, дүүргийн Засаг даргад, тусгай хэрэгцээний газарт бол хариуцсан захирагчид, хилийн зурваст бол хил хамгаалах ерөнхий газрын харьяа тусгай ангийн удирдлагад хүлээлгэж өгнө.

## **24 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл**

24.1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Геодезийн, Зураг зүйн, Кадастрын зураглалын гэж 3 төрлөөр 3 жилийн хугацаатай олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

24.2.Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд дараахь баримт бичгийг бүрдүүлж өгнө:

24.2.1.инженер, техникийн ажилтнуудын жагсаалт, мэргэжлийн дипломын баталгаажуулсан хуулбар, иргэний үнэмлэхний хуулбар;

24.2.2.инженер, техникийн ажилтнуудын нийгмийн даатгалын цахим лавлагаа;

24.2.3. зөвлөх инженер, мэргэшсэн инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар;

24.2.4.үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, нормативын баримт бичиг;

24.2.5.боловсруулалтын техник, програм хангамжийн дэлгэрэнгүй мэдээлэл;

24.2.6.хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл, баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар.

24.3.Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь энэ хуулийн 24.2.6-д зааснаас бусад баримт бичгийг бүрдүүлж өгнө.

24.4.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад бүрдүүлэх баримт бичиг:

24.4.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлт;

24.4.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг дүгнэсэн тэмдэглэл;

24.4.3.энэ хэсгийн 24.2 дахь хэсэгт дурдсан баримт бичиг.

24.5.Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж дараах суурь нөхцөл, шаардлага хангасан байна:

24.5.1.геодезийн инженер-2, нэг нь геодезийн хэмжилт, зураглалын эсвэл агаарын зураглал боловсруулалтын чиглэлээр зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх,

24.5.2.геодезийн хэмжилтийн багаж \электрон тахеометр, GNSS-ийн 2 долгионы багаж, нивелир\-тай байх,

24.6.Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь зураг зүйн зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй инженертэй, боловсруулалтын техник, програм хангамжтай байна.

24.7.Кадастрын зураглал эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж дараах суурь нөхцөл, шаардлага хангасан байна:

24.7.1.геодезийн инженертэй байх,

24.7.2.геодезийн хэмжилтийн багаж \электрон тахеометр, GNSS-ийн 2 долгионы багаж\-тай байх,

24.8.Дараахь тохиолдолд геодези, зураг зүйн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагын дүгнэлтийг үндэслэн геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ:

24.8.1.энэ хуулийн 7-11 дүгээр зүйл, 23.1.2-23.1.7-д заасан шаардлагыг зөрчсөн;

24.8.2.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хоёр жил дараалан эрхлээгүй.

24.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны мэдээ, тайланг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

24.10.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн, инженер техникийн ажилтны, хэмжилтийн багажны мэдээллийн санг хөтөлнө.

24.11.Инженерийн барилга байгууламжийн угсралтын, уул уурхайн ашиглалтын өдөр тутмын геодезийн хэмжилтийн ажлыг тусгай зөвшөөрөлгүй гүйцэтгэж болно.

24.12.Гадаадын иргэн, хуулийн этгээдэд геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

24.13.Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж нь Архивын тухай хуулийн дагуу үйл ажиллагааны баримтын архив үүсгэж, хадгална.

24.14.Аж ахуйн нэгж татан буугдахад \үйл ажиллагаа зогсоох\ архивын баримтыг салбарын төрийн архивт шилжүүлнэ.

24.15.Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж нь Архивын тухай хуулийн дагуу хадгалалтын хугацаа дууссан баримтыг салбарын төрийн архивт шилжүүлнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ**

#### **25 дугаар зүйл. Геодези, зураг зүйн улсын хяналт**

25.1.Геодези, зураг зүйн улсын хяналт нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэний геодези, зураг зүйн талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан норматив баримт бичгийн биелэлтийг хангана.

25.2.Геодези, зураг зүйн улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага болон аймаг, нийслэлд ажиллах геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

25.3.Геодези, зураг зүйн улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

#### **26 дугаар зүйл. Геодези, зураг зүйн ажилд магадлал хийх**

26.1.Геодези, зураг зүйн ажилд магадлалыг батлагдсан журмын дагуу, ажлын 15 хоногт багтаан хийнэ.

26.2.Магадлалыг дараахь геодези, зураг зүйн ажлын үр дүнд хийнэ:

26.2.1.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, ажлын даалгавар;

26.2.2.геологийн дунд масштабын зураглалын геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл;

26.2.3.уул уурхайн ашиглалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад ашигласан геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл;

26.2.4.хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө зохиоход ашигласан геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл;

26.2.5.инженерийн дэд бүтцийн томоохон байгууламжийн төлөвлөлт, байгуулалтад ашигласан геодези, байр зүйн суурь өгөгдөл, мэдээлэл.

26.3.Энэ хуулийн 26.2 дахь хэсэг гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан геодези, зураг зүйн бүтээгдэхүүнд нэгэн адил хамаарна.

26.4.Энэ хуулийн 26.2, 26.3-т заасан ажлын үр дүнд магадлал хийлгээгүй бол геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээн авахыг хориглоно.

26.5.Энэ хуулийн 26.2.1-д дурдсан ажлын даалгавар, техникийн төсөл, техник, эдийн засгийн үндэслэлд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан баримт бичигт дахин магадлал хийлгэнэ.

26.6.Магадлалын дүгнэлт татгалзсан, зөвшөөрсөн гэсэн хоёр хэлбэртэй байна. Магадлалын татгалзсан дүгнэлт нь тухайн ажлыг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

26.7.Энэ хуулийн 26.6-д заасан магадлалын дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлж болно.

26.8.Захиалагчийн хүсэлтээр геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийж болно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.**

### **ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН УЛСЫН НЭГДСЭН САН**

#### **27 дугаар зүйл. Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөг**

27.1.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан /цаашид “нэгдсэн сан” гэх/ нь геодезийн сүлжээний, байр зүйн, агаар, сансрын, газар зүйн нэрийн, хаягийн, кадастрын болон сэдэвчилсэн зургийн мэдээлэл, тэдгээртэй холбогдох бусад тоон мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан хөмрөг нь төрийн өмч байна.

27.2.Иргэн, хуулийн этгээд нь улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллагын хэрэгжүүлж буй төслийн хөрөнгө, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт (каталог), бүдүүвч зураг, бичлэг, бусад тоон мэдээллийг нэгдсэн санд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

27.3.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, бусад материалыг худалдан авч болно.

27.4.Нэгдсэн сан хөмрөг нь дараахь зүйлээс бүрдэнэ:

27.4.1.Энэ хуулийн 5.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны үр дүнд үүссэн газрын зураг, хэвлэлийн эх, гэрэл зургийн хальс, тайлан, солбицлын жагсаалт (каталог), бусад тоон мэдээлэл;

27.4.2.энэ хуулийн 27.2-т заасны дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн материал;

27.4.3.бусдад худалдах, олшруулах эрхгүйгээр байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс худалдан авсан, энэ хуулийн 27.4.1, 27.4.2-т зааснаас бусад онц чухал материал;

27.4.4.байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс өөрсдийн үйл ажиллагаа, бүтээлийг сурталчлах зорилгоор нэгдсэн санд ирүүлж байгаа зураг, тоон мэдээлэл, тоног төхөөрөмжийн тухай танилцуулга.

27.5.Энэ хуулийн 27.4-т заасан мэдээллийг хүлээн авах, нийтэд үйлчлэх журмыг энэ хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Архивын тухай хуульд нийцүүлэн геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.

27.6.Нэгдсэн сангийн мэдээллийн мета-өгөгдлийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нийтэд мэдээлэх үүрэгтэй.

27.7.Нэгдсэн сангийн мэдээллийн мета-өгөгдөл нь дараах мэдээллээс бүрдэнэ:

27.7.1.мэдээллийн нэр, товч тайлбар;

27.7.2.мэдээллийн чанарын тодорхойлолт;

27.7.3.мэдээллийн үндсэн эх сурвалж;

27.7.4.мэдээллийн дүрслэл, солбицлын тогтолцоо;

27.7.5.мэдээллийн хэрэглээ, түгээлт.

27.8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 27.4.2-д заасан мэдээллийг мета-өгөгдлийн хамт шилжүүлнэ.

27.9.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газрын зураг захиалж хийлгэхдээ урьд өмнө нь тухайн газар нутагт геодези, зураг зүйн ажил хийгдэж байсан эсэхийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангаас нягтлана.

27.10.Газрын зургийг гүйцэтгэлийн зургаар баяжуулна.

27.11.Геодези, зураг зүйн өгөгдөл, бүтээгдэхүүнийг нэгдсэн портал сайтаар дамжуулан нийтийн хүртээл болгоно.

## **ДОЛДУГААР ЗҮЙЛ.**

### **БУСАД ЗҮЙЛ**

#### **28 дугаар зүйл. Санхүүжилт**

28.1.Улсын захиалга, даалгавраар хийх геодези, зураг зүйн ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

28.2.Геодези, зураг зүйн улсын чанартай ажлын захиалагч нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд жил бүр улсын захиалга, даалгаврыг боловсруулж улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

28.3.Тухайн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч нь холбогдох төрийн захиргааны байгууллага, орон нутагт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч нь тухайн шатны засаг дарга байна.

28.4.Геодезийн байнгын цэг тэмдэгтийг хамгаалах, тооллого хийх нөхөн сэргээхтэй холбоотой зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

28.5.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний захиалгаар хийгдэх геодези, зураг зүйн ажлыг захиалагчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

28.6.Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, гудамж, зам, талбай, шугам сүлжээний холболт, мод цэцэрлэгжүүлэлтийг шинээр хийх, өөрчлөх, нөхөн сэргээх зэрэг газар шорооны ажил хийсэн талбайд гүйцэтгэлийн зураг хийлгэх, түүнд шаардагдах зардлыг захиалагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

28.7.Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах сантай байна.

28.8.Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө захиалгаар хийгдэж буй геодези, зураг зүйн ажлын нийт төсөвт өртгийн зургаан хувийг захиалагчийн хяналт шалгалт, магадлалд, нэг хувийг энэ хуулийн 28.7-д заасан санд төвлөрүүлнэ.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ.**

### **БУСАД ЗҮЙЛ**

#### **29 дүгээр зүйл. Хориглох үйл ажиллагаа**

29.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дараах геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

29.1.1.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр геодезийн цэгийг шилжүүлэх, устгах, гэмтээх, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулах;

29.1.2.газар зүйн албан ёсны нэрийг өөрчлөн хэрэглэх, гадаад хэлэнд орчуулах;

29.1.3.геодезийн хэмжилтийн баталгаажуулаагүй багаж ашиглах;

29.1.4.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх;

29.1.5.тусгай зориулалтын газрын зураг, тоон мэдээллийг холбогдох төрийн захиргааны байгууллагын хяналтгүйгээр хэвлэх, хуулбарлах, олшруулах;

29.2.Гадаадын хуулийн этгээд монгол улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

29.3.Газрын зургийн масштабыг томруулан зохиосон, хэрэглэсэн, эсхүл зурган, тоон мэдээллийг хуулбарлан ашиглахыг хориглоно.

### **30 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх**

30.1.Геодезийн хэмжилт хийх, цэг байгуулах явцад газар, барилга байгууламж, бусад объектод учруулсан хохирлыг тухайн үйл ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлнө.

30.2.Гүйцэтгэсэн ажлын нарийвчлал, стандартын шаардлага хангагдаагүйгээс учирсан шууд хохирлын нөхөн төлбөрийг гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

30.3.Геодезийн цэгийг устгасан, хэмжилт хийх нөхцлийг алдагдуулсан бол буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээнэ.

### **31 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

31.1.Энэ хуулийг 2019 оны ..дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ